



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ
/2020 оны III улирал/

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

/2020 оны III улирал/

Тайланд карт гаргагч, хүлээн авагч 12 банк, карт хүлээн авагч 1 байгууллагын төлбөрийн карт, төхөөрөмж, бусад төлбөрийн хэрэгсэл, Монголбанкаар дамжсан их, бага дүнтэй гүйлгээний мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар нэгтгэж, үзүүлэв. Картын хэрэглээг хот ба орон нутгаар, идэвхтэй болон идэвхгүй ашиглагдаж байгаа гэж ангилахаас гадна картын нэр төрлөөр (₮ карт, Виза, Мастеркарт, ЮнионПэй, Американ Экспресс, ЖейСиБи) тус бүрт нь авч үзэв. Мөн картын үйлчилгээнд ашиглагдаж буй төхөөрөмжийн тоо (ПОС, МПОС, ПОБ, АТМ¹, СDM², CRM³, Цахим худалдаа, Киоск⁴), карт ашиглан хийсэн гүйлгээний тоо, дүнг карт гаргагч, хүлээн авагч банкаар, өөрийн болон бусад клирингийн системд хийгдсэн байдлаар ангилж үзүүлээ.


Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй ба багцын гүйлгээний Автомат клиринг хаус (АСН+) систем болон их дүнтэй гүйлгээний Банксүлжээ системээр дамжсан гүйлгээний тоо, дүнг улирлаар авч үзэн, өөрчлөлт ба нийт гүйлгээнд эзлэх хувь хэмжээг

тодорхойлов. Тайланд дурдагдсан тоон мэдээллийг нэгтгэсэн хүснэгтийг хавсралтаар үзүүлэв.

1. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

• Картын тоо

Банкуудын гаргасан картын тоо 2020 оны III улирлын байдлаар 3.9 сая ширхэг байгаа нь өмнөх оны III улирлын үзүүлэлттэй харьцуулахад 215.4 мянган ширхэгээр буюу 5.8 хувиар өссөн байна. Нийт картын 48.1 хувь буюу 1.9 сая карт идэвхтэй ашиглагдаж байгааг Зураг 1-т үзүүлэв.



Идэвхтэй ашиглагдаж байгаа картын тоо өмнөх оны III улирлын үзүүлэлтээс 403.3 мянга буюу 27.1 хувиар өссөн байна (Хүснэгт I).

¹ АТМ зөвхөн бэлэн мөнгөний зарлага хийнэ

² СDM зөвхөн бэлэн мөнгөний орлого хийнэ


³ CRM бэлэн мөнгөний орлого, зарлага хийнэ

⁴ ПОС төхөөрөмжтэй

Картын хэрэглээний тайлан (өссөн дүнгээр сая ширхэг)

Хүснэгт I	2019 он, III улирал	2020 он, III улирал	Өсөлт/бууралт (2019-III/2020-III)	
			Тоо	Хувь
Картын тоо	3,715,957	3,931,395	215,438	5.80%
Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо	1,486,855	1,890,129	403,274	27.12%

Картын хэрэглээг аймаг, хотоор авч үзвэл 2020 оны III улирлын байдлаар орон нутагт 1.3 сая ширхэг төлбөрийн карт ашиглагдаж байгаа нь өмнөх оны III улирлын үзүүлэлтээс 185.8 мянган ширхэг буюу 16.4 хувиар нэмэгдсэн байна. Хотуудын хувьд карт эзэмшигчдийн тоо 2.6 сая ширхэг байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 29.6 мянган ширхэг буюу 1.2 хувиар өссөн байгааг Зураг 2-т үзүүлэв.



Өмнөх оны III улирлын 69.4% ба 30.6%-тай харьцуулахад тайлант улирлын байдлаар нийт карт эзэмшигчдийн 66.4% нь хот, 33.6% нь орон нутгийн иргэд байгаа нь орон нутаг дахь карт эзэмшигч нэмэгдэж байгааг харуулж байна. (Хүснэгт II).

Картын хэрэглээний тайлан

Өссөн дүнгээр

Хүснэгт II	2019 он, III улирал	2020 он, III улирал	Өсөлт/бууралт (2019-III/2020-III)	
			Тоо	Хувь
Хотууд	2,579,370	2,608,959	29,589	1.15%
Бусад аймгууд	1,136,587	1,322,436	185,849	16.35%

Банкуудын зүгээс техник технологийн дэвшлийг ашиглаж, үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлснээр санхүүгийн байгууллагын үйлчилгээг карт эзэмшигчид хүргэх боломж нэмэгдэж байгаа нь хөдөө, орон нутагт амьдарч буй иргэдийн картын тоо өсөх шалтгаан болж байна.

Банкууд 6 төрлийн картыг өөрийн банкны оноосон нэрээр гаргаж байгаа ба эдгээрийн тоо хэмжээг төрөл тус бүрээр нь Хүснэгт 1б-д үзүүлэв. Тайлант хугацаанд 2.5 сая ширхэг буюу нийт картын 63.7 хувийг үндэсний брэнд ₮ карт, 20.8 хувийг ЮнионПэй карт, 12.4 хувийг Виза карт тус тус эзэлж байна. Харин Мастеркарт, Американ Экспресс болон ЖейСиБи картууд хамгийн бага буюу 0.1-ээс 2.9 хүртэлх хувийг эзэлж байгааг Зураг 3-т үзүүлэв. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны III улирлын үзүүлэлттэй харьцуулахад Амекс картын тоо 29.8 хувиар, ЖейСиБи картын тоо 9.8 хувиар, ₮ картын тоо 7.2 хувиар тус тус буурсан. Тайлант хугацаанд Мастеркарт картын тоо 118.4 хувиар, ЮнионПэй

картын тоо 40.8 хувиар, Виза картын тоо 30.5 хувиар өмнөх оны үзүүлэлтээс тус тус нэмэгдсэн байна.




• **Төхөөрөмжийн тоо**


Өмнөх оны III улиралд төхөөрөмжийн тоог 5 нэр төрлөөр ангилж бүртгэдэг байсан бол, 2019 оны IV улирлаас эхлэн шинэ зааврын дагуу төхөөрөмжийн тоог 4 төрлөөр нэмж, нийт 9 төрлөөр бүртгэдэг болсон. Үүнд ПОС, МПОС, ПОБ, АТМ, СДМ, СRМ, Цахим худалдаа болон Киоск төхөөрөмжүүд багтана. Нийт төхөөрөмжийн 88.8 хувийг ПОС, 3.7 хувийг ПОБ, 2.7 хувийг МПОС, 2 хувийг СRМ, 1.4 хувийг АТМ эзэлж байгаа бол бусад төхөөрөмжүүд 0.1-ээс 1.1 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 4-д үзүүлэв.

Орон даяар хэрэглэгдэж буй нийт төхөөрөмжийн тоог өмнөх оны III

улиралтай харьцуулахад 16.5 мянган ширхэг буюу 26.6 хувиар өссөнөөр 78.4 мянган ширхэг болоод байна (хавсралтын Хүснэгт 2б).



Төхөөрөмжийн тоог хот, аймаг тус бүрээр харьцуулж үзэхэд улсын хэмжээний нийт төхөөрөмжийн 23.5 хувь нь орон нутагт, 76.5 хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байршиж байгаа нь хүн амын төвлөрөлтэй холбоотойгоор төлбөрийн картын хэрэглээ хотуудад төвлөрсөн хэвээр байгааг харуулж байна (хавсралтын Хүснэгт 2а).



● **Гүйлгээний тоо, дүн**

Банкууд өөрийн гаргасан картаар Өөрийн банкны сүлжээ, ҮЦГТ-ийн Нэгдсэн сүлжээ болон Гадаад сүлжээнд гүйлгээг хийж байгаагаас 5.9 их наяд төгрөгийн 91.4 сая ширхэг буюу бүх сүлжээнд хийгдсэн нийт картын гүйлгээний тооны 62.8 хувийг, нийт дүнгийн 56.3 хувийг үндэсний брэнд ₮ карт эзэлж байгаа бол, ЮнионПэй карт нийт гүйлгээний тооны 22.9 хувийг, дүнгийн 22.7 хувийг, Виза карт нийт гүйлгээний 13.4 хувь, дүнгийн 20.2 хувийг эзлэж байна. Харин Мастеркарт, Американ экспресс болон ЖейСиБи картууд харьцангуй бага буюу гүйлгээний тооны 0.03-аас 0.9, дүнгийн 0.04-өөс 0.7 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 5-д үзүүлэв.

Төлбөрийн системийн оролцогчид өөрөө гаргаснаас гадна дотоодын бусад

байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд карт уншигч төхөөрөмжөөр дамжуулан хүлээн авдаг. Тайлант хугацаанд нийт 10.2 их наяд төгрөгийн 139.4 сая ширхэг гүйлгээг амжилттай хүлээн авсан нь өмнөх улирлын үзүүлэлтээс гүйлгээний дүнгийн хувьд 9.2 хувиар буурсан ч, гүйлгээний тооны хувьд 23.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт III).


Өөрийн, дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр (бэлэн, бэлэн бус) мянган ширхэг, тэрбум төгрөг

Хүснэгт III	Бэлэн бус									
	ПОС		МПОС		Цахим худалдаа		АТМ/СRM		КИОСК (пос-той)	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019-III улирал	80,178.48	2,071.88	108.21	1.4	0	0	4,880.17	3,502.16	0	0
2020-III улирал	109,091.15	2,505.27	19.11	0.70	405.36	48.62	4,164.16	2,737.04	86.28	1.97
Өөрчлөлт	28,912.67	433.39	-89.10	-0.70	405.36	48.62	-716.02	-765.12	86.28	1.97
Өөрчлөлт %	36.06%	20.92%	-82.34%	-49.81%	100.00%	100.00%	-14.67%	-21.85%	100.00%	100.00%

Бэлэн								Нийт	
ПОС		ПОБ		АТМ/СRM зарлага		СDM/СRM орлого			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
190.08	8.37	398.52	116.44	27,330.50	5,485.86	0.00	0.00	113,085.96	11,186.11
147.72	6.86	370.92	84.41	19,392.22	2,644.81	5,717.92	2,126.44	139,394.84	10,156.11
-42.36	-1.51	-27.61	-32.03	-7,938.28	-2,841.05	5,717.92	2,126.44	26,308.88	-1,030.00
-22.28%	-18.10%	-6.93%	-27.51%	-29.05%	-51.79%	100.00%	100.00%	23.26%	-9.21%

Төхөөрөмжөөр хийгдсэн нийт гүйлгээг Бэлэн бус, Бэлэн гэж ангилж байгаагаас ПОС төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний тоо хамгийн их буюу нийт бэлэн бус гүйлгээний 95.9 хувийг эзэлж байгааг Хүснэгт III-ын үзүүлэлтээс харж болно. Гүйлгээний дүнгийн хувьд АТМ/СRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн нийт төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 51.7 хувийг эзэлж байна. Бэлнээр хийгдсэн гүйлгээний тоо ба дүнгийн хувьд АТМ/СRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ нийт бэлнээр хийгдсэн гүйлгээний тооны 75.7, дүнгийн 54.4 хувийг эзэлж байна.


Гүйлгээний тоо ба дүнг төхөөрөмж тус бүрээр авч үзвэл 109.2 сая ширхэг, 2.5 их наяд төгрөгийн гүйлгээ ПОС төхөөрөмжөөр хийгдсэн нь өмнөх оны III улиралд хийгдсэн гүйлгээний тооноос 35.9 хувь, гүйлгээний дүн 20.8 хувиар өссөн байна. АТМ, СDM, СRM төхөөрөмжүүдээр энэ оны III улиралд нийт 29.3 сая ширхэг, 7.5 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оноос тооны хувьд 9.1 хувиар, дүнгийн хувьд 16.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгааг Зураг 6-д үзүүлэв.



Тайлант улиралд ПОБ төхөөрөмжөөр нийт 84.4 тэрбум төгрөгийн 370.9 мянган гүйлгээ хийгдсэн байгаа нь өмнөх оны III улирлын үзүүлэлтээс дүнгийн хувьд 27.5, тооны хувьд 6.9 хувиар тус тус буурсан байна. МПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулахад 108.2 мянган ширхэгээс 19.1 мянган ширхэг гүйлгээ болж 82.3 хувиар буурсан, дүнгийн хувьд 702.7 сая гүйлгээ болж 49.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Цахим худалдааны хувьд 2019 оны IV улирлаас төхөөрөмжийг тусад нь бүртгэж эхэлсэн тул өмнөх оны III улиралд гүйлгээ бүртгэгдээгүй. Харин энэ оны III улиралд Цахим худалдаагаар 48.6 тэрбум төгрөгийн 405.4 мянган ширхэг гүйлгээ хийгдсэн байна (хавсралтын Хүснэгт 4).

Сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөрийн хэрэгсэлийн хэрэглээ нэмэгдэж байгааг Зураг 7-д үзүүлээ. Бэлэн бус төлбөрийн хэмжээ 2016 онд нийт картын гүйлгээний 43.5 хувийг эзэлж байсан бол 2017 оноос 56.1 болж нэмэгдсээр 2018 онд 65.3 хувь, 2020 оны III улирлын байдлаар 81.6 хувьд хүрчээ. Харин бэлэн гүйлгээний хэрэглээ 2016 онд картын нийт гүйлгээний 55.6 хувийг эзэлж байсан бол 2017 оноос буурсаар 2018 онд 33.2 хувь, 2020 оны III улирлын байдлаар 18.4 хувь болсон байна. Энэ нь иргэд төлбөрөө бэлэн бусаар хийх хандлага өссөөр байгааг харуулж байна (хавсралтын Хүснэгт 4).


Бэлэн бус гүйлгээний хэрэглээ дүнгийн хувьд 2016 онд нийт картын гүйлгээний дүнгийн 15.4 хувийг эзэлж байсан бол 2020 оны III улирлын байдлаар 52.1 хувьд хүрчээ. Харин бэлнээр хийгдсэн гүйлгээний дүн 2016 онд нийт картын гүйлгээний 83 хувийг эзэлж байсан бол 2020 оны III улирлын байдлаар 47.9 хувь болж бэлэн бусаар хийгдсэн гүйлгээ дүнгийн хувьд бэлнээр хийгдсэн гүйлгээнээс илүү хувийг эзэлж эхэлснийг Зураг 8-д үзүүлээ.



ҮЦГТ-ын нэгдсэн сүлжээнд 2020 оны III улиралд хийгдсэн гүйлгээний тоо ба дүнг Худалдаа үйлчилгээний төрлөөр ангилсан хураангуйг Хүснэгт IV-өөс харж болно. Хүснэгтээс үзэхэд хүнсний дэлгүүр, супермаркет, хоолны газар болон АТМ-д хамгийн их буюу хэрэглэгчдийн дийлэнх гүйлгээ төвлөрдөг бол харилцаа холбооны төлбөр, шатахууны төлбөр болон шөнийн цэнгээний газарт хийгдсэн гүйлгээ хамгийн бага хувийг эзэлж байна. Хүснэгт IV -ийн үзүүлэлтийг хувьчилж Зураг 9 ба 10-т үзүүлэв.


Хүснэгт IV. ҮЦГТ-өөр дамжсан картын гүйлгээний дүнд худалдаа үйлчилгээнтэй төрлөөр (2020-III)		
ТОП 15 болон бусад /Гүйлгээний дүнгээр/	КУБ дугаар	мөнгөн дүн
1.Хүнсний дэлгүүр, супермаркет	5411	458,429,173,813
2.АТМ-ын гүйлгээ	6011	392,953,044,400
3.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/	5499	88,591,438,512
4.Хоолны газар, ресторан	5812	84,910,915,726
5.Шатахуун түгээх газар	5542	73,115,526,886
6.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр	5912	57,690,998,750
7.ПОБ-ын гүйлгээ	6010	52,810,301,880
8.Гэр бүлийн хувцасны дэлгүүр	5651	45,952,080,555
9.Их дэлгүүр	5311	44,054,672,621
10.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр	5691	42,870,715,122
11.Шөнийн цэнгээний газар, паб	5813	28,209,606,519
12.Эмнэлэг	8062	28,195,649,420
13.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/	5983	27,258,954,261
14.Автомашинны үйлчилгээний цэгүүд	5541	25,867,416,405
15.Цахилгаан хэрэгслийн дэлгүүр	5732	21,711,370,110
16.Бусад		514,486,351,793
НИЙТ		1,987,108,216,773

Зураг 9. 2020 оны III улирлын картын гүйлгээний дүнд эзлэх хувь



Хүснэгт V. ҮЦГТ-өөр дамжсан картын гүйлгээний тоо худалдаа үйлчилгээнтэй төрлөөр (2020-III)		
ТОП 15 болон бусад /Гүйлгээний тоогоор /	КУБ дугаар	Гүйлгээний тоо
1.Хүнсний дэлгүүр, супермаркет	5411	32,112,253
2.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/	5499	7,206,709
3.АТМ-ын гүйлгээ	6011	4,852,550
4.Хоолны газар, ресторан	5812	4,203,748
5.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр	5912	3,202,998
6.Шатахуун түгээх газар	5542	1,696,308
7.Их дэлгүүр	5311	1,364,690
8.Түргэн хоолны газар	5814	1,185,367
9.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр	5691	920,026
10.Төрөлжсөн бус барааны дэлгүүр	5331	917,289
11.Гэр бүлийн хувцасны дэлгүүр	5651	885,478
12.Автомашин үйлчилгээний цэгүүд	5541	835,531
13.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/	5983	721,722
14.Шөнийн цэнгээний газар, паб	5813	707,258
15.Харилцаа холбооны үйлчилгээ	4814	703,790
16.Бусад		11,762,562
НИЙТ		73,278,279

Зураг 10. 2020 оны III улирлын картын гүйлгээний тоонд эзлэх хувь



Залилангийн гүйлгээ.

Тайлант хугацаанд нийт 160 удаагийн үйлдлээр 60.2 сая төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны III улиралтай харьцуулахад гүйлгээний тоо 48.2 хувиар, дүн нь 155 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт ба,б,в). Үүнд:

- Картын төрлөөр:
 1. Ү карт 41 удаагийн үйлдлээр 5.3 сая төгрөг;
 2. Виза карт 90 удаагийн үйлдлээр 42.9 сая төгрөг;
 3. ЮнионПэй 25 удаагийн үйлдлээр 11.8 сая төгрөг;
 4. Американ экспресс 4 удаагийн үйлдлээр 146.9 мянган төгрөг.
- Төхөөрөмжийн төрлөөр:
 1. ПОС 20 удаагийн үйлдлээр 1.6 сая төгрөг;
 2. АТМ/СRМ 54 удаагийн үйлдлээр 16.2 сая төгрөг;
 4. Цахим худалдаа 86 удаагийн үйлдлээр 42.5 сая төгрөгийн залилангийн гүйлгээ тус тус хийгдсэн байна (Хүснэгт ба,б,в).

2. ТӨЛБӨРИЙН БУСАД ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ

Тайлант хугацаанд төлбөрийн бусад хэрэгслээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг ангилж үзэхэд дараах үзүүлэлттэй байна. Банкуудын илгээсэн гүйлгээг төлбөрийн хэрэгслээр тодруулбал:

- Бэлэн мөнгө – 6 их наяд төгрөгийн 2.8 сая ширхэг;
- Кредит шилжүүлэг – 47.5 их наяд төгрөгийн 19.9 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 23 тэрбум төгрөгийн 11.3 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 6.6 их наяд төгрөгийн 64.8 мянган ширхэг (Хүснэгт 5).

Харин банкуудын хүлээн авсан гүйлгээг төлбөрийн хэрэгслээр задалбал:

- Бэлэн мөнгө – 6 их наяд төгрөгийн 3.8 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 77.3 тэрбум төгрөгийн 47.3 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 5.1 их наяд төгрөгийн 54.6 мянган ширхэг (Хүснэгт 5).

Дээрх үзүүлэлтээс үзэхэд банканд дээр хийгдэж буй харилцагчийн гүйлгээнээс шилжүүлгийн төрөл өмнөх оны үзүүлэлтийн адилаар нийт гүйлгээний тооны хамгийн их буюу 74.5 хувийг, мөн гүйлгээний дүнгийн 66.5 хувийг эзэлж байгаа бол мөнгөн гуйвуулга дүнгийн хувьд

хамгийн бага буюу нийт гүйлгээний дүнгийн 0.14 хувийг, мөн нийт гүйлгээний 0.2 хувийг эзэлж байна.

3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээний тооны дийлэнх хувийг бага дүнтэй гүйлгээ, дүнгийн ихэнх хувийг их дүнтэй гүйлгээ тус тус эзэлдэг харьцаа тайлант улиралд хэвээр хадгалагджээ. 2020 оны III улирлын байдлаар нийт гүйлгээний тооны 70.8 хувь буюу 17.4 сая ширхэгийг бага дүнтэй гүйлгээ (RTP), 27.5 хувь буюу 6.8 сая ширхэгийг багцын гүйлгээ (ACH), үлдсэн 1.7 хувийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна. Харин нийт гүйлгээний дүнгийн 94.9 хувь буюу 86.7 их наяд төгрөгийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна (Хүснэгт 7).

Бага дүнтэй гүйлгээний тоог өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 2.7 сая ширхэг буюу 18.4 хувиар, их дүнтэй гүйлгээний тоо 39.6 мянган ширхэг буюу 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Их дүнтэй гүйлгээний дүнг өмнөх оны III улиралтай харьцуулахад 15.8 их наяд буюу 22.2 хувиар, бага дүнтэй гүйлгээний дүн 872.4 тэрбум буюу 27.2 хувиар өссөн байна.

I. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ
Хүснэгт 1а. Картын хэрэглээний тайлан

(Өссөн дүнгээр)

	2019 он, III улирал	2020 он, III улирал	Өсөлт/бууралт (2019-III-2020-III)	
			Тоо	Хувь
Картын тоо	3,715,957	3,931,395	215,438	5.80%
Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо	1,486,855	1,890,129	403,274	27.12%
Картын тоо	Хотууд	2,579,370	29,589	1.15%
	Бусад аймгууд	1,136,587	185,849	16.35%

Хүснэгт 1б. Картын хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/07/2020 - 30/09/2020

№	Хот, аймаг	₮ карт		Виза				Мастеркарт				ЮнионПэй				Амекс				ЖейСиБи				Нийт картын тоо
		Энгийн		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		
		Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	
1	Улаанбаатар	1,385,111	25,073	326,065	60,952	0	0	89,553	2,737	13,051	0	165,837	9,108	218,222	48,250	1,111	2,237	0	0	4,510	0	0	0	2,351,817
2	Дархан-Уул	84,216	1,408	7,786	2,579	0	0	525	60	168	0	17,882	209	8,564	2,957	197	7	0	0	256	0	0	0	126,814
3	Орхон	84,022	1,073	10,837	2,785	0	0	564	101	232	0	18,850	353	8,869	2,118	141	24	0	0	359	0	0	0	130,328
	Нийт (дээрх хотууд)	1,553,349	27,554	344,688	66,316	0	0	90,642	2,898	13,451	0	202,569	9,670	235,655	53,325	1,449	2,268	0	0	5,125	0	0	0	2,608,959
	Нийт эзлэх %	63.14%		84.51%				95.45%				61.42%				91.17%				57.15%				66.36%
4.00	Бусад аймгууд	904,129	18,826	59,731	15,620	0	0	3,486	483	1,130	0	221,380	2,951	87,647	2,850	295	65	0	0	3,843	0	0	0	1,322,436
	Нийт эзлэх %	36.86%		15.49%				4.55%				38.58%				8.83%				42.85%				33.64%
	Нийт (Улс)	2,457,478	46,380	404,419	81,936	0	0	94,128	3,381	14,581	0	423,949	12,621	323,302	56,175	1,744	2,333	0	0	8,968	0	0	0	3,931,395
	Нийт (Улс)	2,503,858		486,355				112,090				816,047				4,077				8,968				3,931,395

Хүснэгт 1в. Карт эзэмшигч - Нэр төрлөөр

2017 - 2020 он (картын тоо өссөн дүнгээр)

Он	₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖейСиБи	Нийт
2017 он, III улирал	2,713,197	697,180	23,069	382,922	15,228	169	3,831,765
2018 он, III улирал	2,987,830	648,250	9,665	439,828	6,626	956	4,093,155
2019 он, III улирал	2,696,629	372,655	51,327	579,590	5,809	9,947	3,715,957
2020 он, III улирал	2,503,858	486,355	112,090	816,047	4,077	8,968	3,931,395
<i>Өсөлт/бууралт (2020-III)</i>	<i>-7.15%</i>	<i>30.51%</i>	<i>118.38%</i>	<i>40.80%</i>	<i>-29.82%</i>	<i>-9.84%</i>	<i>5.80%</i>
<i>Нийт зах зээлд эзлэх хувь</i>	<i>63.69%</i>	<i>12.37%</i>	<i>2.85%</i>	<i>20.76%</i>	<i>0.10%</i>	<i>0.23%</i>	<i>100.00%</i>

Хүснэгт 2а. Төхөөрөмжийн хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/07/2020 - 30/09/2020

№	Хот, аймаг	ПОС	МПОС	ПОБ	АТМ	СДМ	СРМ	Цахим худалдаа	"КИОСК (пос-той)"	Бусад	Нийт
1	Улаанбаатар	49,806	1,871	1,433	697	31	1,140	858	142	0	55,978
2	Дархан-Уул	1,835	120	81	49	4	40	2	4	0	2,135
3	Орхон	1,704	3	72	44	1	38	0	8	0	1,870
	Нийт (Хотууд)	53,345	1,994	1,586	790	36	1,218	860	154	0	59,983
	<i>Нийт эзлэх %</i>	<i>76.61%</i>	<i>95.59%</i>	<i>54.32%</i>	<i>71.43%</i>	<i>87.80%</i>	<i>76.85%</i>	<i>98.29%</i>	<i>86.52%</i>	<i>#DIV/0!</i>	<i>76.49%</i>
4	Бусад аймаг	16,284	92	1,334	316	5	367	15	24	0	18,437
	<i>Нийт эзлэх %</i>	<i>23.39%</i>	<i>4.41%</i>	<i>45.68%</i>	<i>28.57%</i>	<i>12.20%</i>	<i>23.15%</i>	<i>1.71%</i>	<i>13.48%</i>	<i>#DIV/0!</i>	<i>23.51%</i>
	Нийт (Улс)	69,629	2,086	2,920	1,106	41	1,585	875	178	0	78,420

Хүснэгт 2б. Төхөөрөмжийн тоо

2018 - 2020 он (төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр)

№	Төхөөрөмж	2018 он, III улирал	2019 он, III улирал	2020 он, III улирал	Өсөлт/бууралт (2019-III/2020-III)		<i>Нийт төхөөрөмжид эзлэх хувь</i>
					Тоогоор	Хувиар	
1	ПОС	37,458	54,214	69,629	15,415	28.43%	88.79%
2	МПОС	4,014	2,915	2,086	-829	-28.44%	2.66%
3	ПОБ	2,240	1,932	2,920	988	51.14%	3.72%
4	АТМ	2,257	2,519	1,106	-1,413	-56.09%	1.41%
5	СДМ	0	0	41	41	100.00%	0.05%
6	СРМ	0	0	1,585	1,585	100.00%	2.02%
7	Цахим худалдаа	0	0	875	875	100.00%	1.12%
8	Киоск	0	0	178	178	100.00%	0.23%
9	Бусад	0	342	0	-342	-100.00%	0.00%
	Нийт	45,969	61,922	78,420	16,498	26.64%	100.00%

Хүснэгт 3а. Өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Картын төрлөөр

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

	₮ карт		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс		ЖейСиБи		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт	46,398.13	4,748.56	7,931.63	1,539.54	422.44	28.08	17,190.25	1,928.89	33.99	7.03	17.25	1.40	71,993.68	8,253.49

Хүснэгт 3б. Өөрийн гаргасан картаар нэгдсэн, гадаад сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Хүлээн авагч төхөөрөмж	Нэгдсэн сүлжээ												Гадаад сүлжээ								Нийт			
		₮ карт		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс		ЖейСиБи		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс				ЖейСиБи	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ПОС	42,461.60	844.59	10,211.33	342.19	714.87	25.20	15,304.54	341.75	0.00	0.00	60.94	1.23	253.33	39.28	10.49	0.77	6.66	2.52	6.03	2.69	0.41	0.07	69,030.22	1,600.29
2	ПОБ	139.76	29.86	40.28	12.84	0.97	0.21	43.40	11.01	0.00	0.00	0.07	0.02	9.67	2.03	0.00	0.00	0.04	0.23	0.00	0.00	0.00	0.00	234.19	56.20
3	АТМ	2,419.37	255.61	477.49	58.31	39.65	5.23	789.42	77.60	0.00	0.00	8.83	1.06	26.13	20.57	0.64	0.85	6.27	5.20	0.06	0.04	0.09	0.08	3,767.95	424.54
4	Цахим худалдаа	9.66	0.43	11.83	0.53	0.18	0.03	19.64	0.59	0.00	0.00	0.01	0.00	491.89	89.56	103.30	10.60	0.91	0.15	3.64	1.36	0.22	0.01	641.28	103.27
	Нийт	45,030.39	1,130.49	10,740.93	413.87	755.67	30.67	16,157.00	430.95	0.00	0.00	69.85	2.31	781.03	151.44	114.43	12.22	13.88	8.10	9.73	4.08	0.73	0.16	73,673.64	2,184.30

Хүснэгт 4. Төхөөрөмж тус бүрээр хийсэн гүйлгээний дүн, тоо

2019 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төхөөрөмж	Утга	2019 он, III улирал	2020 он, III улирал	Өсөлт/бууралт (хувиар)
1	ПОС	Тоо	80,368.56	109,238.87	35.92%
		Дүн	2,080.25	2,512.13	20.76%
2	МПОС	Тоо	108.21	19.11	-82.34%
		Дүн	1.4	0.70	-49.81%
3	ПОБ	Тоо	398.52	370.92	-6.93%
		Дүн	116.44	84.41	-27.51%
4	АТМ/CRM/CDM	Тоо	32,210.67	29,274.30	-9.12%
		Дүн	8,988.02	7,508.29	-16.46%
5	Цахим худалдаа	Тоо	0	405.36	100.00%
		Дүн	0	48.62	100.00%
6	Киоск	Тоо	0	86.28	100.00%
		Дүн	0	1.97	100.00%
7	Бусад	Тоо	0	0	100.00%
		Дүн	0	0	100.00%
Нийт (Улс)		Тоо	113,085.96	139,394.84	23.26%
		Дүн	11,186.11	10,156.11	-9.21%

Хүснэгт 5. Төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тайлан - Илгээсэн гүйлгээ

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

Гүйлгээний төрөл	Бэлэн мөнгө		Кредит шилжүүлэг		Гуйвуулга						Гадаад шилжүүлэг (SWIFT)		Нийт	
	Тоо	Дүн	Тоо		Western Union		Moneygram		Бусад мөнгөн гуйвуулга		Тоо	Дүн	Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Илгээсэн гүйлгээ	2,842.55	6,009.08	19,928.24	47,490.48	1.11	1.42	1.99	5.85	8.15	15.69	64.82	6,642.03	22,846.85	60,164.55
Хүлээн авсан гүйлгээ	3,800.52	6,046.70	0.00	0.00	6.90	15.22	28.82	44.50	11.60	17.57	54.58	5,096.70	3,902.41	11,220.70

Хүснэгт 6а. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Картын төрлөөр

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№		Өөрийн гаргасан карт						Дотоодын бусад банкны гаргасан карт						Гадаадын байгууллагын гаргасан карт					Нийт	
		₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖейСиБи	₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖейСиБи	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖейСиБи		
1	Тоо	0.027	0.083	0.000	0.017	0.004	0.000	0.014	0.007	0.000	0.008	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.160
2	Дүн	0.004	0.042	0.000	0.007	0.000	0.000	0.001	0.001	0.000	0.005	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.060

Хүснэгт 6б. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

01/07/2020 - 30/09/2020

№	Байршил	Төхөөрөмж	Тоо	Дүн
1	Монгол улс	ПОС	20.00	1,572,450.00
2		МПОС	0.00	0.00
3		АТМ/СRМ	38.00	11,271,000.00
4		Цахим худалдаа	0.00	0.00
5	Олон улс	ПОС	0.00	0.00
6		АТМ/СRМ	16.00	4,880,482.60
7		Цахим худалдаа	86.00	42,461,914.88
Нийт			160	60,185,847.48

Хүснэгт бв. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

2018 - 2020 он (сая төгрөгөөр)

Он	Утга	ПОС	АТМ/СRM	Цахим худалдаа	Бусад	Нийт
2018 он, III улирал	Тоо	33	165	0	18	216
	Дүн	0.72	94.96	0	5.67	101.35
2019 он, III улирал	Тоо	1	25	82	0	108
	Дүн	1.33	7.2	15.07	0	23.6
2020 он, III улирал	Тоо	20	54	86	0	160
	Дүн	1.6	16.1	42.5	0	60.2
Өсөлт/бууралт (хувиар)	Тоо	1900%	116%	5%	0%	48%
	Дүн	20%	124%	182%	0%	155%

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Хүснэгт 7. Их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн

2018-2020 он (мянган ширхэг, их наяд төгрөг)

	2018 он				2019 он ⁵				2020 он			
	тоо	%	дүн	%	тоо	%	дүн	%	тоо	%	дүн	%
I улирал	9,295.8	32.2	20.0	46.5	13,021.6	40	69.1	245.5	12,920.10	-0.78	67.20	-2.74
Бодит цагийн гүйлгээ (RTP)	8,808.8	32.3	1.2	44.0	12,727.4	44.5	2.5	108	12,599.90	-1.00	3.05	22.02
Багцын гүйлгээ (ACH)	-		-		-		-		-		-	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	487.0	29.2	18.8	46.8	294.2	-39.58	66.6	254.2	320.20	8.84	64.15	-3.67
II улирал	10,992.3	45.9	22.8	15.2	14,856.3	35.2	78.2	242.8	22,014.99	48.19	84.45	8.06
Бодит цагийн гүйлгээ (RTP)	10,379.7	47.0	1.4	48.4	14,474.4	39.4	3.05	117.9	15,498.30	7.07	3.65	19.67
Багцын гүйлгээ (ACH) ⁶	-		-		-		-		6,113.57	-	0.64	-
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	612.6	29.8	21.4	13.0	381.9	-37.7	75.1	250.9	403.12	5.56	80.16	6.74
III улирал	10,850.6	117.0	19.7	13.6	15,114	39.3	74.1	276.1	24,626.75	62.94	91.33	23.25
Бодит цагийн гүйлгээ (RTP)	10,232.2	126.3	1.4	65.5	14,727.2	43.9	3.2	128.6	17,435.66	18.39	4.07	27.19
Багцын гүйлгээ (ACH)	-		-		-		-		6,764.71	-	0.61	-
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	618.4	29.4	18.2	11.1	386.8	-37.5	70.9	289.6	426.38	10.23	86.65	22.21
IV улирал	12,898.7	98.0	27.7	38.5	17,532.4	35.9	87.6	216.3				
Бодит цагийн гүйлгээ (RTP)	12,311.6	107.3	2.1	90.9	17,099.4	38.9	3.7	76.1				
Багцын гүйлгээ (ACH)	-		-		-		-					
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	587.1	1.9	25.6	34.7	433.0	-26.3	83.9	227.8				
Нийт	44,037.40	68.8	90.16	27.3	60,524.3	37.4	309.0	242.7				
Бодит цагийн гүйлгээ (RTP)	41,732.27		6.08		59,028.4		12.4					
эзлэх хувь	95.0		7.0		97.5		4.0					
Багцын гүйлгээ (ACH)	-		-		-		-					
эзлэх хувь												
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	2,305.13		84.03		1,495.9		296.5					
эзлэх хувь	5.0		93.0		2.5		96.0					

⁵ Өмнөх тайлангуудад их дүнтэй гүйлгээний тоон мэдээг оруулахдаа зөвхөн арилжааны банкуудын дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулдаг байсан бөгөөд 2019 оны I улирлаас эхлэн Монголбанкны өөрийн дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулах болсонтой холбоотойгоор дүнгийн хувьд огцом өссөн үзүүлэлттэй байна.

⁶ Багцын гүйлгээ нь нэгж гүйлгээний дүнгийн хязгаарлалт байхгүй тул Бага дүнтэй гүйлгээн дээр бүртгэдэг байсныг 2020 оны II улирлаас эхлэн өөрчилж, ашиглагдаж буй систем тус бүрээр нь ялгаж бүртгэдэг болсон.